



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



THE WORLD BANK  
IBRD • IDA | WORLD BANK GROUP



JICA  
Japan International  
Cooperation Agency



ADB  
ASIAN  
DEVELOPMENT  
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

СУУРЬ БОЛОВСРОЛЫН  
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ  
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

УРАН ЗОХИОЛ

УЛААНБААТАР 2021





БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



THE WORLD BANK  
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ASIAN  
DEVELOPMENT  
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

СУУРЬ БОЛОВСРОЛЫН  
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ  
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ

# ЗӨВЛӨМЖ

УРАН ЗОХИОЛ

*АНХНЫ ХЭВЛЭЛ*

УЛААНБААТАР 2021



## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

---

Суралцагчийн үнэлгээ.....	2
---------------------------	---

## СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

---

Нэг. Уран зохиолын суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн онцлог .....	5
Хоёр. Шалгуурт суурилсан үнэлгээ .....	7
2.1. Нэгж хичээл ба үнэлгээний нэгж .....	7
2.2. Суралцахуйн зорилт ба суралцахуйн үр дүн .....	9
2.3. Үнэлгээний шалгуур ба гүйцэтгэлийн түвшин.....	13
Гурав. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар .....	19
3.1. Үнэлгээний даалгавар боловсруулах нь .....	19
3.2. Нэгж хичээлийн үнэлгээний даалгаврын жишээ: .....	21
Дөрөв. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал.....	24

## СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго<sup>1</sup>/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх<sup>2</sup>/, үнэлж дүгнэх<sup>3</sup> зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ **“шалгуур”**-г суурилсан байна.

### ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд **“үнэлгээ”**-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

<sup>1</sup> Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

<sup>2</sup> Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариулыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

<sup>3</sup> Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад<sup>4</sup> нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

## ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



<sup>4</sup> Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.





## Нэг. Уран зохиолын суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн онцлог

Суурь боловсролын түвшинд бичвэрт төвлөрсөн уншлага буюу зохиолыг задлан шинжлэх арга зүйг суралцахуйн арга барилд хялбаршуулан буулгах замаар суралцагчдад чадвар эзэмшүүлэхийг зорьдог. Өөрөөр хэлбэл унших, ярих-сонсох, бичих үйл давамгайлдаг онцлогтой хичээл тул унших чадварт суурилан, задлан шинжилж бичих, ярих-сонсох суралцахуйн үр дүнг үнэлнэ.

Суурь ба бүрэн дунд боловсролын зорилт:

Агуулгын ай	Суурь				Бүрэн дунд			Бүрэн дунд /сонгон/		
	VI	VII	VII	IX	X	XI	XII	X	XI	XII
Унших	7	7	7	7	7	7	7	3	4	6
Бичих	3	3	2	2	2	2	2	2	2	2
Ярих-сонсох	2	2	1	1	1	1	2	1	1	1
Бүгд	12	12	10	10	10	10	11	6	7	9
	49				31			22		

Уран зохиолын суралцахуйн зорилт 49 /заавал судлах/ буй бөгөөд хичээл сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, удирдаж чиглүүлэх, зааж хэрэгжүүлэх, үнэлгээ дүгнэлт хийх зэрэгт мөрдлөг болгож байгаа билээ. Уран зохиолын хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсруулахдаа ч суралцахуйн зорилтыг багцалж, нэгтгэж “Суралцахуйн үр дүнг” боловсруулсан.

Уран зохиолын хичээл нь унших, ярих, сонсох, бичих үйлийн нэгдэл юм.

- ✓ Сурагч яаж уншиж байна, яаж ярьж, сонсож байна, ямар хандлага төлөвшиж байна, ямар үнэт зүйлийг бүрдүүлж байгаа болон бүрдүүлж болохыг зорилго болгодгоороо онцлог.
- ✓ Өөр өөр цаг үеийн уянга, туульс, жүжиг, шүлэглэсэн болон үргэлжилсэн үгийн хэлбэрээр бичсэн түүх, соёл, нийгмийн онцлог байдал, үндэсний ухамсар, ёс суртахууны суурь үнэт

зүйлсийг хамгаалсан сэдэвтэй, цагийн шалгарлыг давж үнэлэгдсэн, найруулгын хувьд үлгэр жишээ зохиолуудаас судалдаг.

- ✓ Мөн өрнө дорнын нийгэм соёлын олон янз байдлыг тусгасан, хүний эрх, эрх чөлөө, ёс суртахууны суурь үнэт зүйлсийг хамгаалсан сэдэвтэй, шилдэг бүтээлээс уншдаг.
- ✓ Монголын болон гадаадын зохиолоос уншиж, түүх, нийгэм, соёлын хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар мэдлэг ойлголт эзэмшүүлж, *задлан шинжлэх арга барилтай, мэдрэмжтэй, сэтгэгч, хүмүүнлэг уншигчийг төлөвшүүлэхийг* зорьдог.
- ✓ Зохиолыг бүрэн эхээр уншин, сэдэв, өгүүлэгдэхүүн, дүр, орчин, хэл найруулгын онцлогийг тодруулж уншигчийн тайлал тайлбар, ярих чадварыг хөгжүүлдгээрээ бусад судлагдахуунаас ялгардаг онцлогтой.
- ✓ Суралцахуйн зорилтод тулгуурласан суралцахуйн үр дүн нь бүхэллэг бөгөөд нэгж хичээл бүрээр дахин давтан хэрэгжихээр томъёологдсон. Тухайлбал: 6.1б,6.в,6.1г, 6.1д,6.1е, 7.1б,7.1г, 7.1в,7.1д,7.1е, 8.1б,8.1в,8.1г,8.1д,8.1е, 9.1б,9.1в,9.1г,9.1д,9.1е,9.1ж
- ✓ Нэгж /сургалтын тодорхой үйл ажиллагаа явуулсны/ хичээлийн дараа зорилгодоо хүрсэн эсэхийг тогтоохын тулд сурагч бүрийн чадвар, дадал, хандлага, мэдлэг чадварын ахиц амжилтыг тооцдог. Сурагчийг үнэлж дүгнэхдээ зохиолыг тусган хүлээн авснаа амаар буюу бичгээр илэрхийлж буй чадварыг; зохиолыг задлан шинжлэх арга барил эзэмшсэнийг; шүлэглэсэн зохиолын онцлогийг таних, санаа бодлоо илэрхийлэн мэтгэлцэх чадвар зэргийг үнэлдэг.

Уран зохиолын хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсруулахдаа суурь боловсролын хөтөлбөрийг үндэслэл болгосон. Ингэхдээ:

- ✓ Тодорхой зорилго чиглэлтэй байх
- ✓ Шалгалтын агуулга нь судалсан зүйлийн агуулгын түвшинд таарч байх
- ✓ Нас, сэтгэхүй, хувийн онцлогт тохирсон арга хэлбэртэй байх
- ✓ Уян хатан байх
- ✓ Шударга, ил тод, ойлгомжтой байх
- ✓ Шалгалт тасралтгүй, систем дэс дараалалтай байх
- ✓ Судалсан зүйлийн агуулгыг бүрэн хамарсан байх
- ✓ Үнэлгээ бодитой, үнэн байх
- ✓ Шинжлэх ухааны үндэстэй байх зэрэг сургалтын болон үнэлгээний зарчмуудыг баримталсан.

## Хоёр. Шалгуурт суурилсан үнэлгээ

### 2.1. Нэгж хичээл ба үнэлгээний нэгж

НЭГЖ ХИЧЭЭЛ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ хоёр нь өөр ойлголт гэдгийг ойлгох нь чухал. Бид суралцахуйн зорилтод үндэслэн суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуурыг боловсруулсан юм. Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуурт /ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮРЭХ ТҮВШИН/ Блумын таксономийн танин мэдэхүйн түвшнийг баримталсан. Тэгэхээр онолын ойлголтоо гүнзгийрүүлэхийн тулд түүнтэй холбоотой ойлголт, ухагдахууныг уншиж, ойлголтоо сайжруулах нь энэхүү үнэлгээний шалгуур зөвлөмжийг хэрэгжүүлэхэд илүү дөхөм байх болно.

НЭГЖ ХИЧЭЭЛ:

Суурь боловсролын уран зохиолын хичээлийн хөтөлбөрийн агуулга нь:

- ✓ Унших
- ✓ Бичих
- ✓ Ярих-сонсох айтай. Ай тус бүр нь зорилттой.

Мөн тухайн ангийн “Уран зохиол”-ын сурах бичигт зохиолын төрөл зүйл /домог, аман яруу найраг, шүлэг, өгүүллэг гэх мэт/-ээр юм уу, эсвэл эртний уран зохиол, орчин үеийн яруу найраг, орчин үеийн хүүрнэл зохиол, гадаадын уран зохиол гэх мэт дарааллын онцлогийг харгалзсан байдаг. Ихэвчлэн сурах бичгийн агуулгад тулгуурлан нэгж хичээлийг төлөвлөж, түүндээ унших, бичих, ярих, сонсох чадварыг багтааж нэгжилдэг. Жишээ нь: ЕБС-ийн сургалтын төлөвлөгөөнд 8-р ангийн Уран зохиолын хичээлийг долоо хоногт 2 цаг, жилд 66 цаг заахаар тусгаснаас “Уран зохиол VIII” сурах бичгээр баримжаалсан нэгж хичээлийн хуваарилалтыг авч үзье.

Суралцахуйн зорилтууд /кодоор/ Монгол аман яруу найраг		I бүлэг	II бүлэг	III бүлэг	IV бүлэг	V бүлэг
		Шүлэг, найраглал	Өгүүлэг, тууж	Хошин жүжиг	Гадаадын уран зохиол	
Унших	8.1а.	+	+	+	+	+
	8.1б.		+	+	+	+
	8.1в.			+	+	+
	8.1г.			+	+	
	8.1д.	+		+	+	+
	8.1е.	+	+	+	+	+
	8.1ж.	+	+			
Бичих	8.2а.			+	+	+
	8.2б.	+	+	+	+	+
	8.2в.	+	+	+	+	+
Ярих, сонсох	8.3а.	+	+			
	8.3б.	+	+	+	+	+
Судлах цаг		18	12	12	12	12

УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ: Үнэлгээний нэгж нь тухайн ангийн агуулгын хувьд сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг илрүүлэн дүгнэх шалгуурыг нэгтгэсэн үнэлэх агуулгын багц шинжтэй бол нэгж хичээл нь сургалтын хөтөлбөрийн агуулгыг томсгосон дидактик нэгжид хуваасан шийдэл бүхий агуулгын хуваарилалт юм. Иймд энэ хоёр ойлголтыг холих хэрэггүй.

- Зохиолыг уншиж ойлгох
- Зохиолыг задлан шинжлэх
- Зохиох, бичих, илтгэх, мэтгэлцэх гэсэн хуваарилалтаар үнэлгээний нэгжийг боловсруулсан.

Үнэлгээний нэгжийг анги бүрээр харуулбал:

#### VI анги

Агуулгын ай	№	Үнэлгээний нэгж	Холбогдох суралцахуйн зорилтын код
Унших	1	Зохиолыг уншиж ойлгох	6.1а.
Бичих	2	Зохиолыг задлан шинжлэх	6.1б, 6.в 6.1г 6.1д 6.1е
Бичих	3	Шүлгийг дуурайн зохиож, уран унших	6.1ж 6.2в 6.3б.
Ярих, сонсох	4	Бичих, ярих	6.2а 6.2б 6.3а.

#### VII анги

Агуулгын ай	№	Үнэлгээний нэгж	Холбогдох суралцахуйн зорилтын код
Унших		Зохиолыг уншиж ойлгох	7.1а.
Бичих		Зохиолыг задлан шинжлэх	7.1б, 7.1г, 7.1в, 7.1д, 7.1е
Бичих		Мэдрэмж сэтгэгдлээ бичих	7.2а, 7.2б, 7.2в.
Ярих, сонсох		Зохиолыг ярих	7.3а, 7.3б.
Бичих		Бичих, ярих	7.1ж.

#### VIII анги

Агуулгын ай	№	Үнэлгээний нэгж	Холбогдох суралцахуйн зорилтын код
Унших		Зохиолыг уншиж ойлгох	8.1а, 8.3б
Бичих		Зохиолыг задлан шинжлэх	8.1б, 8.1в, 8.1г, 8.1д, 8.1е
Бичих		Зохиолоос сэдэвлэн бичих	8.2а, 8.2б, 8.2в.
Ярих, сонсох		Шүлэглэсэн зохиол	8.3а, 8.1ж.

**IX анги**

Агуулгын ай	№	Үнэлгээний нэгж	Холбогдох суралцахуйн зорилтын код
Унших		Зохиолыг уншиж ойлгох	9.1а, 9.2а, 9.2б
Бичих		Зохиолыг задлан шинжлэх	9.1б, 9.1в, 9.1г, 9.1д, 9.1е, 9.1ж
Бичих		Богино өгүүллэг бичих	9.2в
Ярих,сонсох		Санаа бодлоо илэрхийлэн мэтгэлцэх	9.3б
Ярих,сонсох		Уншсан зохиолоо танилцуулан илтгэх	9.3а

Ийнхүү үнэлгээний нэгжийг тогтоохдоо дараах зарчмыг баримталсан. Үүнд:

- ✓ Сургалтын хөтөлбөрийн өөр өөр агуулгын айн ижил төрлийн зорилтуудыг хооронд нь нэгтгэж суралцахуйн нэг үр дүн болгосон. Жишээ нь:

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
7.2а. Уншсан зохиолын сэдэв, утга санаа, дүрээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ бичих 7.2б. Уншсан зохиолд дүр, орчин нэмэх, харилцан яриа оруулах зэргээр үйл явдлыг дэлгэрүүлж бичих 7.2в. Ерөөл, магтаалын шүлэглэлийн туршлага, уран дүрслэл (адилтгал, зүйрлэл)-ийн аргаас суралцан, шүлэг зохиох	Уншсан зохиолын сэдэв, гол санаа, дүр дүрслэлийн талаарх мэдрэмж сэтгэгдлээ бичихдээ дүр, орчин, харилцан яриа оруулан уран дүрслэл ашиглан зохиож бичиж чаддаг болно.

Энэ нь 7-р ангийн “Мэдрэмж сэтгэгдлээ бичих” буюу “Үнэлгээний нэгж-3”-г бий болгосон.

- ✓ Дахин давтах шаардлагагүй агуулгыг тус тусад нь үнэлгээний нэгж болгосон. Жишээ нь: IX ангид “Санаа бодлоо илэрхийлэн мэтгэлцэх” үнэлгээний нэгжид “Санаа бодлоо илэрхийлэн, дүрмийн дагуу мэтгэлцэж чаддаг болно” гэсэн шалгуурыг ээлжит хичээл бүрд хэрэглээд байх боломжгүй.
- ✓ Унших, бичих суурь чадвар нь үргэлжилсэн үйлээр хэрэгждэг тул “Зохиолыг уншиж ойлгох”, “Зохиолын задлан шинжлэх” нэгжийн шалгуур үзүүлэлтүүд дахин давтагдана.
- ✓ Суурь боловсролын түвшинд зохиолыг задлан шинжлэх арга зүйг эзэмшүүлэх нь чухал учраас суралцахуйн ихэнх зорилтыг “Зохиолыг задлан шинжлэх” нэгжид нэгтгэсэн.
- ✓ Үйлийн дарааллыг баримталсан. Зохиолыг уншиж ойлгосны дараа санаа бодлоо илэрхийлэх, задлан шинжлэх, илтгэх, мэтгэлцэх гэх мэт.
- ✓ Түүнчлэн үнэлгээний нэгжийн шалгуур тус бүрийг нэгж, ээлжит хичээлд ижил хэрэглэх боломжгүй бөгөөд соёл, түүх, нийгмийн хам сэдвийн хүрээнд мэдэрч, тусган хүлээн авч ойлгосны дараа тохирох шалгуурыг сонгож хэрэглэнэ.

**2.2. Суралцахуйн зорилт ба суралцахуйн үр дүн**

Суралцахуйн зорилт бол сурагчдын тухайн хичээлээр судалж эзэмших мэдлэг, чадварын илэрхийлэл юм. VIII ангид унших-8, бичих-3, ярих-сонсох-2, бүгд -13 суралцахуйн зорилт байгаа болно. Анги бүрээр товчоолж харьцуулбал:

Агуулга	Унших	Бичих	Ярих-сонсох	Нийт
VI анги	7	3	2	12
VII анги	7	3	2	12
VIII анги	8	3	2	13
IX анги	7	3	2	12
Нийт	29	12	8	49

**Суралцахуйн үр дүн:** Тухайн хөтөлбөрийн төгсгөлд сурагчдын олж авах ёстой мэдлэг, ур чадвар яагаад тэдэнд ашигтай болохыг ойлгоход нь туслах зорилготой.

Дараах шаардлагад үндэслэн суралцахуйн үр дүнг тодорхойлсон.

1. Сургалтын хөтөлбөрийн агуулгаас хэд хэдэн суралцахуйн зорилтыг нэгтгэж ерөнхийлсөн.  
Жишээ нь: VI анги

Суралцахуйн зорилт /кодоор/	Суралцахуйн үр дүн
6.1a.	Сурагч уншсан зохиолоос ойлгосон, тусган хүлээж авсан зүйлээ соёлын хам сэдвийн хүрээнд илэрхийлж чаддаг болсон байна.
6.1б.,6.в.,6.1г.,6.1д.,6.1е.	Сурагч уншсан зохиолын бүтэц-агуулга, хэл-уран дүрслэл, сэдэв-гол санаа, үйл явдал өрнөсөн орчин, дүрийг тодорхойлж чаддаг болсон байна.
6.1ж.,6.2в.,6.3б.	Сурагч шүлэглэсэн зохиолын онцлогт тохирсон шад мөрийг зохиож чаддаг болсон байна. Сурагч цээжилсэн шүлэг, зохиолоо уран уншдаг болсон байна.
6.2a.,6.2б.,6.3a.	Уншсан зохиолоос ойлгосноо амаар болон бичгээр илэрхийлдэг болсон байна.

VII анги

Суралцахуйн зорилт /кодоор/	Суралцахуйн үр дүн
7.1a.	Ардын аман зохиолыг мэдэрч ойлгон, тусгаж хүлээж авах, үндэсний хэл соёл, ёс заншлыг хүндэтгэн суралцаж эх оронч үзэл хандлагатай болно.
7.1б.,7.1г.,7.1в.,7.1д.,7.1е	Сурагч зохиолын бүтэц - агуулга, хэл найруулга - дүрслэл, сэдэв - гол санаа, үйл явдал өрнөсөн орчин, дүрийг задлан шинжилж чаддаг болно.
7.2a.,7.2б.,7.2в.	Уншсан зохиолын сэдэв, гол санаа, дүр дүрслэлийн талаарх мэдрэмж сэтгэгдэлдээ дүр, орчин, харилцан яриа оруулан уран дүрслэл ашиглан зохиож бичиж чаддаг болно.
7.3a.,7.3б.	Зохиолын үг хэллэг, уран дүрслэл ашиглан, дүрийг сонирхолтой сэтгэлд хүрэхээр ярьж /дүрд тоглож/ чаддаг болно.
7.1ж.	Сурагч шүлэглэсэн зохиолын шад холбоцыг тайлбарлаж чаддаг болно.

VIII анги

Суралцахуйн зорилт /кодоор/	Суралцахуйн үр дүн
8.1a.,8.3б	Сурагч зохиолыг уншин соёл түүх, нийгмийн хүрээнд мэдэрч, тусган хүлээж авахдаа зохиолд дэвшүүлсэн асуудлын талаар санаа бодлоо илэрхийлдэг болсон байна.
8.1б., 8.1в., 8.1г., 8.1д., 8.1е.	Уншсан зохиолын агуулга, дэвшүүлсэн асуудлын талаар мэдэрч, тусгаж авснаа илэрхийлэхдээ үг хэллэг, уран дүрслэл, эшлэл ашиглан сэтгэл татахаар ярьж чаддаг.
8.2a.,8.2б.,8.2в.	Богино хэмжээний өгүүллэг зохиож чаддаг болсон байна.
8.3a.,8.1ж.	Сурагч шүлэглэсэн зохиолын шад холбоц, хэмнэлийн тухай тайлбарлан уран уншиж чаддаг болно.

## IX анги

Суралцахуйн зорилт /кодоор/	Суралцахуйн үр дүн
9.1a,9.2a.,9.2б	Уншсан зохиолоо хам сэдвийн хүрээнд мэдэрч, тусган хүлээн авснаа үнэлж дүгнэн илэрхийлж чаддаг болсон байна.
9.1б,9.1в,9.1г,9.1д,9.1е,9.1ж	Суралцагч зохиолын далд утга, өгүүлэгдэхүүний бүтэц, үйл явдлын дарааллын өөрчлөлт, хам сэдэв, дүрийн өсөлт, шад холбоц, бадаглалыг задлан шинжилж; тайлан тайлбарлаж чаддаг болсон байна.
9.2в	Дүр, орчныг хувирган, үйл явдлыг төгсгөн, богино өгүүлэг бичиж чаддаг болсон байна.
9.3б	Санаа бодлоо илэрхийлэн, дүрмийн дагуу мэтгэлцэж чаддаг болно.
9.3а	Бие дааж уншсан зохиолоо бусдад унших хүсэл төрөхүйц, сонирхолтой арга хэлбэрээр танилцуулан илтгэдэг.

- Суралцахуйн зорилтын үндсэн агуулгыг алдагдуулахгүй, нэмж хасахгүйгээр суралцахуйн үр дүн болгосон бөгөөд энэ хоёрыг ижил түвшинтэй байхаар томъёолсон.
- Суралцахуйн үр дүн нь сурах үйл явцыг бус ямар үр дүнд хүрэхийг хоёрдмол санаагүй, шууд ойлгогдохоор тодорхойлсон. Жишээ нь: 9-р ангид “Дүр, орчныг хувирган, үйл явдлыг төгсгөн, богино өгүүлэг бичиж чаддаг болсон байна” гэсэн нь сурагчид зохиолын дүр, орчныг хувирган өгүүлэг бичиж сурах ёстой юм байна гэсэн үр дүнгийн мэдээллийг өгч байна.
- Суралцахуйн үр дүн нь тухайн хөтөлбөрийн хүрээнд эзэмших шаардлагатай хүлээсэн мэдлэг, тусгай болон ерөнхий чадвар, үнэт зүйл, хандлагад чиглэсэн байх ёстой.
- Суралцахуйн үр дүн нь хэмжигдэхүйц, ажиглагдахуйц байх.
- Үнэлгээний шалгуур нь давхцаагүй, нэг нэгнээсээ ялгаатай байх. Жишээ нь:

“Зохиолын дүр” бол бүхий л ангид байгаа боловч агуулгын гүнзгийрэл, мэдлэг чадвар эзэмших ахицаар ялгаатай байна.

	Үнэлгээний шалгуур
VI анги	Зохиолын дүрийн зорилгыг тодорхойлдог.
VII анги	Сурагч зохиолын дүрийг тодорхойлж, үнэлж чаддаг.
VIII анги	Сурагч зохиолын гол ба туслах, сөрөг дүрийг тодорхойлдог.
IX анги	Зохиолын дүрийн зорилго, зан төрх, холбоо хамаарлаас дүрийн өсөлтийг дүгнэдэг.

- Үнэлгээний шалгуур нь боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх. Дээрх хүснэгтээс *тодорхойлдог, тодорхойлж үнэлдэг, дүрийн өсөлтийг дүгнэдэг* гэх мэтчилэн анги бүрийн үнэлгээний шалгуурын үйл үгийг ажиглаж, үнэлж дүгнэхдээ ч нарийн анзааран хэрэглэнэ.

“Суралцахуйн зорилт ба суралцахуйн үр дүн”-г хэрэгжүүлэх талаар зургаадугаар ангийн Уран зохиолын хичээлийн жишээгээр тайлбарлая.

Суралцахуйн зорилтод үндэслэсэн СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН нь: “Сурагч уншсан зохиолоос ойлгосон, тусган хүлээж авсан зүйлээ соёлын хам сэдвийн хүрээнд илэрхийлж чаддаг болсон байна”

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур нь ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮРЭХ /4/ ТҮВШИНТЭЙ.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮРЭХ ТҮВШИН			
I	II	III	IV
Зохиолын агуулгаас ойлгосноо асуултын дагуу товч ярьдаг. Зохиолын агуулга ямар нийгэм, соёлтой холбогдож байгааг ярьдаг.	Зохиолын агуулгаар нь хувааж, хэсэг бүрд тохирсон нэр өгдөг. Зохиолд өгүүлэгдэж байгаа нийгэм, соёлтой холбогдох үг хэллэг, өгүүлбэрийг олж, утгыг таамаглаж, асууж тодруулдаг.	Зохиолын үйл явдлын уялдаа холбоог түлхүүр үг, бүдүүвчээр харуулдаг. Зохиолд үйл явдал нь тухайн нийгэм, соёлын хам сэдэвтэй холбон ойлгож, юуг мэдэрч, тусган хүлээж авснаа илэрхийлдэг.	Зохиолын сэдэв, гол санаа нь нийгэм, соёлын хам сэдэвтэй яаж холбогдож байгааг ойлгож, юуг мэдэрч, тусган хүлээж авснаа илэрхийлдэг.

Үүнээс дүгнэхэд:

Сурагч юу мэдэх, чадах хэрэгтэйг тодруулж өгч байна

Сурагч суралцахуйн үнэ цэн, үр дүнд анхаарлаа хандуулдаг болно.

Суралцахуйн үр дүнгийн өөр түвшинд хүрэхийн тулд юу хийх хэрэгтэйг ойлгоно.

Багш сурагч юунд хүрэх, хүргэхийг зорилт, үр дүн, гүйцэтгэлийн түвшин тодорхой болгож байна.

Харин “Сурагч уншсан зохиолоос ойлгосон, тусган хүлээж авсан зүйлээ соёлын хам сэдвийн хүрээнд илэрхийлж чаддаг болсон байна” гэсэн үр дүнд хүрэхийн тулд зохиолоо хэрхэн уншуулах, хэрхэн уншсан, уншсаныг хэрхэн шинжилж мэдэх тухай өгүүлье.

**Эх зохиол уншсаныг /мэдээлэл хүлээн авсныг/ шинжлэх.** Сурагчид маань эх зохиолыг

- Бүхэлд нь гүйлгэн уншсан
- Зохиолын агуулгыг бусдаар яриулсан
- Ерөнхий тоймлож уншсан
- Зарим хэсгийг алгасан уншсан
- Эх зохиолыг сонсож мэдсэн гэх мэт нь эх зохиолыг ерөнхий байдлаар уншиж, хүлээн авсан бол зайлшгүй хэрэгтэй суурь ойлголт, ухагдахуун, нэр томъёо зэрэг **баримтын мэдлэгтэй** болсон байна.
- Хэсэглэн уншсан /чухал зүйлийг тогтоох зорилгоор/
- Зохиолыг уншихдаа товч тэмдэглэл хийж уншсан
- Түлхүүр үгсийг түүвэрлэн тэмдэглэх, ялгах зэргээр уншсан бол илүү өргөн хүрээний ойлголттой болсон байх ба тэдгээрийн уялдаа холбоо, утга санааг илүү гүн, учир шалтгааны уялдааг олж тайлах чадвартай буюу **ухагдахууны мэдлэгтэй** болсон байна.
- Уншихдаа схем, зураглал, түлхүүр бичиглэл хийсэн
- Эх зохиолыг уншихдаа /өнгийн тодруулагч хэрэглэж, онцолж тэмдэглэсэн/ өөртөө шаардлагатай хэсгийг ялгаж, онцолсон, түүвэрлэн бичсэн
- Зохиолыг хувиргасан бүтээлтэй харьцуулах зэргээр уншсан бол хэрхэн хийж гүйцэтгэх арга аргачлалтай, үр дүйтэй, шинжлэн турших барил буюу **үйлийн мэдлэгтэй** болсон байна.
- Тэмдэглэл /зохиолыг бусдадаа ярьж өгөхүйц/ хийж, илтгэх зорилготой уншсан /бүтээлч, идэвхтэй уншлагын хэлбэр/
- Бүтээлч уншсан /ойр дотнынхонтойгоо яриа өрнүүлж, мэтгэлцсэн/ байвал сэтгэн бодох, асуудал шийдэх, мэтгэлцэх илтгэх, олон талын шийдлүүдэд гаргалгаа хийх, тоймлох, шинжилж дүгнэх, асуудалд тохирсон арга барилыг сонгон хэрэглэдэг буюу **танин мэдэх үйлийг жолоодох мэдлэгтэй** болсон байна. Сурагчийг хэрхэн уншиж ойлгосныг багш судлан тооцох нь хичээлээ зохион байгуулах, үнэлэхэд дөхөм болно. Ер нь эх зохиолыг уншихдаа товч бичиглэл хийж, дахин давтан уншиж, чухал зүйлийг тогтоож цээжилж, бусад бүтээлтэй /дэлгэцийн бүтээл/ харьцуулж, жишиж, бүтээлч, үр дүнтэй унших арга барилтай болгох. Сайн уншигч сурагчийн /бусдын/ аргыг судлан хэрэгжүүлэх, хичээл сургалтдаа турших, бусад хүүхдэд санал болгох зэргээр



багшаас нэлээд санаачилга шаардах болно. Эх зохиолоо ихэнх нь уншаагүй бол уран зохиолын хичээл уншлагын хичээл л болдог доо. Тийм учраас сурагч бүрийг бие даан уншиж сургах л чухал. Энэ бүхэн ганц багшийн тайлбарласнаар бүтэхгүй. Тийм болохоор хамтын оролцоо чухал болно.

## 2.3. Үнэлгээний шалгуур ба гүйцэтгэлийн түвшин

Үнэлгээний шалгуур ба гүйцэтгэлийн түвшин нь сургалтын үр дүнг тодорхойлох үзүүлэлт, хэмжүүр юм.

1. Шалгуур (criterion) нь суралцагчийн хүрсэн үр дүн буюу амжилтыг нотлон харуулахад чиглэсэн үзүүлэлт юм. Түүнчлэн сурагчийн хувьд хүрсэн үр дүн, амжилтыг харуулахын тулд юу хийх ёстойг харуулдаг бол багш нарын хувьд юуг сургасан байх ёстой вэ гэдгийг тодорхой харуулдаг.
2. Гүйцэтгэлийн үзүүлэлт /Achievement Standard, Performance Standard/ бол чанарын тодорхой түвшний /гүйцэтгэл/ тухай ойлголт юм.

### Багшийн хувьд:


- Юуг сургасан байх ёстой вэ гэдгийг илэрхий тодорхой болгосон.
- Сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн яаж, юугаар тодорхойлох, үнэлэх, дүгнэхийг ойлгомжтой болгосон.
- Сурагчийг бусад сурагчтай бус үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлнэ. Өөрөөр хэлбэл тэр сурагч тийм, минийх ийм гэх мэт үнэлгээний талаар зөрчил маргаан үүсэхгүй.
- Сургалтын бодит байдлыг тогтоож үнэлэлт, дүгнэлт хийх чухал баримт болно.

### Сурагчийн хувьд:

- Суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юу хийх ёстойг тодорхой харуулдаг.
- Шалгуур нь суралцагчийн хүссэн үнэлгээндээ хүрэхийн тулд ахиц дэвшлийг эрэмбэлсэн үзүүлэлт болж өгдөг.
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

Сурагчдын амжилтыг хэмжих **шалгуурын** талаар тэдэнд сайн ойлголт өгөх ёстой. Анги танхимд шалгуурыг байршуулж, харуулах нь сурагч ахиц дэвшлийнхээ талаар ерөнхий ойлголттой болоход тусална. Тодорхой асуудлын хүрээнд үйл явцыг харуулсан мэдээлэл өгч, хэр хандаж байгаа болон хаана явааг /гүйцэтгэлийн түвшний/ нь сануулж, сурах үйл ажиллагааг нь чиглүүлэх боломжтой. Сурагчид ч цаашид юу хийх, хаана хүрэхээ төлөвлөх, тооцоолох, бэлтгэх боломжийг олгодог.

Үнэлгээ нь ямар нэг зүйлийн үнэ цэн, ач холбогдолтойг дүгнэхүйн үйл явц юм.



Боловсруулахад баримталсан зарчим.

- Үнэлгээний шалгуур нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцэж байх.
- Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг илрүүлэхүйц, хэмжихүйц байх
- Үнэлгээний шалгуур нь давхцаагүй, нэг нэгнээсээ ялгаатай байх.
- Үнэлгээний шалгуур нь боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх.
- Үнэлгээний шалгуур нь ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулагдсан байх. Оролцогч бүх талууд /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичигдсэн байх.
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх.

Жишээ нь: бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, хэлэлцэх, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, үнэлэх, шүүмжлэх гэх мэт.

Үнэлгээний шалгуур ба гүйцэтгэлийн түвшний тухай гүнзгийрүүлэн ойлгохын тулд 7 дугаар ангийн жишээгээр авч үзье.

Д/д	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур
1	Зохиолыг уншиж ойлгох	<input type="checkbox"/> Түүх, домог, хууч яриаг уншиж соёл, түүхийн хам сэдвийн хүрээнд мэдэрч тусган хүлээж авснаа илэрхийлж чаддаг.
2	Зохиолыг задлан шинжлэх	<input type="checkbox"/> Сурагч зохиолын далд утгыг уран дүрслэлийн учир холбогдлоор тайлбарлаж чаддаг болно.
		<input type="checkbox"/> Сурагч зохиолын сэдэв, гол санааг тодорхойлж чаддаг болно.
		<input type="checkbox"/> Сурагч өгүүлэгдэхүүний бүтэц хэсгүүдийн холбоо хамаарлыг тодорхойлж чаддаг болно.
		<input type="checkbox"/> Зохиолын орчин нөхцөл байдал нь зохиолын сэдэв, утгыг тодруулахад нөлөөлж байгааг тайлбарлаж чаддаг болно.
		<input type="checkbox"/> Сурагч зохиолын дүрийг тодорхойлж, үнэлж чаддаг болно.
3	Мэдрэмж сэтгэгдлээ бичих	<input type="checkbox"/> Уншсан зохиолын талаар мэдрэмж сэтгэгдлээ бичихдээ дүр, орчин, харилцан яриа оруулан уран дүрслэл ашиглан зохион бичдэг.
4	Зохиолыг ярих	<input type="checkbox"/> Зохиолын үйл явдлын талаар ярихдаа үндэсний хэл, соёл, ёс заншлын үнэт зүйлсийн жишээ, баримт, эшлэл ашиглан сонирхол татаж, сэтгэлд хүрэхээр ярьдаг.
5	Шүлэглэсэн зохиол	<input type="checkbox"/> Сурагч шүлэглэсэн зохиолын хэлбэрийг тайлбарлаж чаддаг болсон байна.

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур бүрийн гүйцэтгэлийн хүрэх түвшний үзүүлэлт нь:

I түвшинд гүйцэтгэж байгаа сурагч сэргээн санах, ойлгох

II түвшинд гүйцэтгэж байгаа сурагч холбох, хэрэглэх

III түвшинд гүйцэтгэж байгаа сурагч задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх

IV түвшинд гүйцэтгэж байгаа сурагч үнэлэх, бүтээх чадвартай болсон байхаар ялгарч байгаа юм. Гүйцэтгэлийн хүрэх түвшнийг дан ганц танин мэдэхүйн түвшнээр ялгарч байна гэж үзэж болохгүй. Мөн агуулгын өргөсөл, гүнзгийрэл, үйлийн алхам болж байгаа гэж ойлгоно.

6, 7, 8, 9-р ангийн үнэлгээний эхний нэгжүүд “Зохиолыг уншиж ойлгох” бөгөөд VI ангийн “Уншсан зохиолын агуулгыг ойлгож, түүнээс тухайн үндэстний соёлын хам сэдвийн хүрээнд тусгаж авснаа амаар болон бичгээр илэрхийлдэг” болохын тулд шалгуурын гүйцэтгэлийн хүрэх түвшнийг хэрхэн авч үзэх вэ?

*Зохиолын агуулгаас ойлгосноо асуултын дагуу товч ярьдаг. Зохиолын агуулга ямар нийгэм, соёлтой холбогдож байгааг ярьдаг.*

Зохиолын агуулгын хаанаас ч асуулт асуусан богино хариулт өгч чаддаг сурагчдыг заавал асуултад хариулж чадаж байна, одоо бич гэж давхар ажил болгохгүйгээр дараагийн түвшинд тохирсон даалгаврыг өгөх нь сурагчийн хөгжлийг дэмжиж байгаа хэрэг болно.

*Зохиолын агуулгаар нь хувааж, хэсэг бүрд тохирсон нэр өгдөг. Зохиолд өгүүлэгдэж байгаа нийгэм, соёлтой холбогдох үг хэллэг, өгүүлбэрийг олж, утгыг таамаглаж, асууж тодруулдаг.*

Зохиолын агуулгыг хэсэглэн хувааж нэр өгч байгаа нь эхийг хураан илэрхийлж буй арга бөгөөд өмнөхөөс арай өөр чадвараа харуулж буй хэрэг юм. Мөн нийгэм, соёлын холбоотой үг, хэллэгээр асуудлыг тодруулж байна. Гэвч хэд хэдэн хичээлийн дараа ийм түвшний сурагчид маань нэгэнт арга барил нь сууж, чадвартай болдог тул энэ түвшинд нь уяад байх шаардлагагүй.

*Зохиолын үйл явдлын уялдаа холбоог түлхүүр үг, бүдүүвчээр харуулдаг. Зохиолд үйл явдал нь нийгэм, соёлын хам сэдэвтэй хэрхэн холбогдож байгааг мэдэрч, тусган хүлээж авснаа илэрхийлдэг.*

Энэ түвшинд задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх чадварыг зохиолын уялдаа холбоог нийгэм, соёлын хам сэдэвтэй уялдуулж хөгжүүлнэ. Сурагчдын ихэнхийг энэ түвшинд хүргэвэл таны шавь оюун тэлж, өсөж байна, сургалт ч үр дүнтэй байгаагийн илрэл юм. Хүүхэд бүр адилгүй тул ахиц дэвшилтэй сурагч бүрийг мөн энэ түвшинд байлгах шаардлагагүй.

*Зохиолын сэдэв, гол санаа нь нийгэм, соёлын хам сэдэвтэй яаж холбогдож байгааг ойлгож, юуг мэдэрч, тусган хүлээж авснаа илэрхийлдэг.*

Өмнөх түвшнээсээ ялгаатай нь /өмнөх зохиолын уялдаа холбоог хам сэдэвтэй холбож байсан бол/ зохиолын сэдэв, гол санаа нь нийгэм, соёлын хам сэдэвтэй яаж холбогдож байгааг буюу үнэлж бүтээж байгаагаар ялгарч байгаа юм. Сурагчдын ихэнх нь энэ түвшинд хүрвэл уран зохиолын хичээл маань жинхэнэ утгаараа зорилгоо биелүүлж буй юм.

Тэгвэл хичээлийн явцад багш сайн ажиглагч, тэмдэглэгч байх. Хичээл заах явцад хэн нь илүү сайн хөгжөөд байгааг дэвтэрт нь, эсвэл хувийн журналдаа тэмдэглээд байх хэрэгтэй. Хүүхэд бүр ижил байдаггүйг бид ойлгож байгаа. Тэгвэл түрүүлж хийчхээд байгаа сурагчийг яах вэ?, бүр таг чиг суугаад байгааг яаж хөгжүүлэх үү?, ихэнх нь аль түвшинд байна вэ? гэдэгт үнэлгээний шалгуур туслах юм.

Зарим сурагчид ярих, санаагаа хэлэх байтугай асуултад хариулахаас ч айдаг. Энэ байдал сурах үйл ажиллагаанд саад болдог. Гэрийн хүмүүжил, эсвэл доог тохуу хийх, шүүмжлүүлэх, буруудахаас айх зэрэг нь аман үнэлгээний нөлөөг хязгаарладаг. Харин багш энэ байдлыг судлах хэрэгтэй. Зарим сурагчид огт ярьж хэлж чадахгүй мөртөө бичгийн ажлыг дориун гүйцэтгэдэг шүү дээ. Тийм учраас асуулт даалгаврын хариуг бичүүлж ахиц амжилтыг тооцох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл аман бичгийн хэлбэрийг хослуулна.

**Жич:** Уран зохиолын хичээлийн үнэлгээний шалгуурыг нэгж хичээлдээ төлөвлөж ажиллах талаар бүрэн дунд боловсролын зөвлөмжөөс харна уу. Түүнд судлах зохиолын төрөл зүйл, агуулга, хэмжээнээс хамаарч ямар үр дүнд хэдийд хүрэхээ график төлөвлөгөө гарган ажиллахыг хүснэгтээр харуулсан байгаа.

### **Явцын үнэлгээнд үнэлгээний шалгуурыг хэрэглэх**

Хичээл сургалтын үйл ажиллагаандаа өдөр тутам явцын үнэлгээг хэрэглэдгийн учир нь сурагчдынхаа давуу болон сул талыг тодорхойлж, сурагчдыг ахиц дэвшил гаргах, сурах арга барил суулгах, сэтгэх чадварыг тэлэх, өөрийн удирдлагатай суралцахад нь дэмжлэг үзүүлэх зэрэг давуу талуудтай.

Явцын үнэлгээ нь сурах үйл ажиллагаанд дараах байдлаар дэмжлэг үзүүлдэг.

- Сурагчидтай суралцахуйн зорилгын талаар ярилцах
- Тэд юу мэдэж, чадаж байгааг ойлгох
- Чанартай гүйцэтгэл ямар байдаг, түүнд хүрэхийн төлөө яаж ажиллах, ямар арга зам байгааг ойлгоход туслах
- Өөрийн болон анги хамт олны үнэлгээг дэмжих
- Сурагчдын цаашид хийх алхмуудыг нарийвчлан чиглүүлсэн зөвлөмж /фийдбак/-ийг өгөх.

Явцын үнэлгээг өдөр бүр хичээл сургалтдаа хэрэгжүүлэх олон арга байдаг.

- Суралцагчдаас хүлээж буй үр дүнгүүдийг тэдэнд мэдээлэх
- Гол чухал ажлыг ялган танихад нь туслах
- Өөрийн ажлын сайжруулах шаардлагатай талуудыг тодорхойлоход туслах
- Хичээлийн турш ахиц дэвшлийг хянах
- Сурагчийн буруу ойлголтыг тодорхойлох
- Сурагчдад хоцрогдож байгаа зүйлээ тодорхойлоход нь туслах
- Амжилтыг урамшуулан сайшаах.

Явцын үнэлгээ бол анги танхимын үйл ажиллагааны нэг чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тасралтгүй хэрэгжүүлснээр сурагчийг чадавхыг нэмж, ахиц дэвшилд хөтөлж байдаг билээ.

Явцын үнэлгээнд олон арга хэлбэрийг ашиглахаас гадна үнэлгээний шалгуурыг хэрхэн хэрэглэх вэ? гэдэг чухал. Үнэлгээний шалгуурыг нээлттэй, ил тод байлгаснаар сурагч ахиц дэвшлээ тооцож мэдэж байх боломжийг бүрдүүлж байгаа. Гагцхүү багш дэмжиж, хөгжлийг дэмжигч, чиглүүлэгч байх ёстой. Үлгэрлэвэл: 7 ангийн үнэлгээний “Задлан шинжлэх” нэгжийн: “Сурагч зохиолын далд утгыг уран дүрслэлийн учир холбогдлоор тайлбарлаж чаддаг болно” суралцахуйн үр дүнг хэрэгжүүлэхдээ шалгуурт тохирсон ялгаатай даалгаврыг өгөх. Тийм учраас багш шалгуурын ялгааг сайтар ойлгох нь чухал юм.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮРЭХ ТҮВШИН			
I	II	III	IV
Уран дүрслэл (амьдчилал, адилтгал)-ийн аль нэгийг эхэд хэрэглэсэн учрыг тайлбарладаг.	Уран дүрслэл (амьдчилал, адилтгал)-ийг хоёуланг нь эхэд хэрэглэсэн учрыг тайлбарладаг.	Зохиогчийн үг сонголт, уран дүрслэл (амьдчилал, адилтгал)-ийг эхэд хэрэглэсэн учрыг тайлбарладаг.	Зохиолчийн үг сонголт /онцлог/, уран дүрслэлийн учир холбогдлоор далд утгыг тайлбарладаг.

I түвшний шалгуур бол амьдчилал, адилтгалын жишээг олохоос гадна аль нэгийнх нь эхэд хэрэглэсэн учрыг тайлбарлаж чаддаг байна. Нөгөөг нь эс чадна. Үүний тулд л шалгуурыг алхамчилж нарийвчилсан хэрэг. Суралцагч аль нэгийнх нь /эхэд хэрэглэсэн/ учрыг тайлбарлаж чадахгүй, эсвэл төөрөгдөөд байгааг багш ч мэддэг, сурагч өөрөө мэддэг бол түүнд тохирсон дасгал даалгавар өгнө. Оноосон дасгал ажлыг сурагчид гүйцэтгэнэ. Зөвлөхдөө “Чи үүнийг мэдэж байгаа юм чинь үүнийг бол чадна” гэж дэмжихээс өгсүүлээд яагаад ингэж илэрхийлэв, үүгээрээ дамжуулж ямар утгыг далдалсан байна, илрүүлдэг ийм ийм арга байдаг гэдгийг жишээнд тулгуурлан тайлбар хийх, үзэж судалж буй зохиолоос нь жишээ олуулж тайлбарлуулна. Эсвэл амьдчилал, адилтгалын аргыг өргөн хэрэглэсэн зохиол, үздэг кино гэх мэтэд тулгуурлан гүйцэтгүүлнэ.

II түвшний шалгуур хангахын тулд амьдчилал, адилтгал эхэд хэрэглэсэн учрыг тайлбарладаг чадвартай байна. Үүний тулд зохиолд ийм ийм адилтгал амьдчилал/-ыг хэрэглэжээ. Хэрэглэсэн учрыг жишээд тулгуурлан тайлбарлуулна. Амьдчилал бол амьд юмны шинж чанарыг төстэй байдлаар нь амьгүй бодист шилжүүлэн аваачиж дүрсэлдэг. Ийм жишээг олуулаад эхэд ямар үүрэг гүйцэтгэв, үүгээр дамжуулж хүний зан чанар, нийгэм, соёлыг утга далдлагдав. Адилтгал бол хоёр юм үзэгдлийн адил төстэй байдалд үндэслэсэн байдаг. Адилтгагч адилтгуулагчийн харьцаагаар ямар далд утгыг илэрхийлж байна. Эдгээр нь зохиолыг уран сайхан болгоход хэрхэн нөлөөлдгийг жишээгээр тайлбарлуулна.

III түвшний шалгуур хангахын тулд амьдчилал, адилтгалын хоёуланг эхэд хэрэглэсэн учрыг тайлбарладаг чадвартай байхаас гадна зохиогчийн үг сонголтын учрыг тайлбарладаг байх. Өөрөөр хэлбэл зохиолын дүр болон аливаа зүйлийн тодотгож байгаа үг хэллэг ямар үүрэгтэй хийгээд онцлогтой болохыг тайлбарладаг болно. Ингэхийн тулд судалж буй зохиолын онцлог үгийг сонгон тайлбарлуулна.

IV түвшний шалгуур хангах сурагч нь зохиолчийн үг сонголт /амьдчилал, адилтгал/-ын онцлогийг тайлбарлахаас гадна уран дүрслэлийн учир холбогдлоор далд утгыг хэрхэн бүтээж байгааг тайлбарлах чадвар юм. Энэ мэтээр үнэлгээний шалгууруудыг явцын үнэлгээнд үр дүнтэй хэрэгжүүлж чадвал задлан шинжилж тайлбарлах чадвар нь ахих болно. Тайлбарлана гэдэг бол нэгхэн үйлээр хязгаарлагдахгүй хэрэг. Бодох, шалтгааныг олох, эргэцүүлэх, ярих, бичих гээд олон үйлдлүүдийн нийлбэр юм.

### Оношлох үнэлгээнд үнэлгээний шалгуурыг хэрэглэх

Сургалт эхлэхээс өмнө буюу явцад /улирлын эхэнд юм уу тодорхой бүлэг сэдвийг судлахын өмнө/ суралцагчийн мэдлэг чадварыг түвшинчилнэ. Үнэлгээний үр дүнд багш хичээлээ юунаас эхлэх, сурагчид ямар мэдлэг, чадвартай байгааг мэдэх боломж олгоно. Тухайн сэдвээр суралцагчид хангалттай мэдлэг, чадвартай байвал хичээлийн агуулгыг өргөжүүлэн, хүндэвтэр дасгал даалгаврыг сонгоно. Хэрэв суралцагчид хангалтгүй байвал үндсэн ойлголт өгөх, дөхүүлэх ба энгийн болон хөнгөвчилсөн дасгал, давтлагыг гүйцэтгүүлэх зэргээр ажиллах хэрэгтэй болно. Үлгэрлэвэл:

VII ангид “Уншсан зохиолын талаар мэдрэмж сэтгэгдлээ бичихдээ дүр, орчин, харилцан яриа оруулан уран дүрслэл ашиглан зохион бичдэг” суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуурыг ашиглан өмнөх ангид судалсан нэг зохиолыг сонгон авч бичүүлнэ. Мэдээж энэ шалгуураар үнэлнэ гэдгээ нээлттэй байлгана. Ингэж өгөх нь ч тустай. Зарим идэвхтэй сурагчийн хувьд шалгалтдаа бэлтгэхийн тулд дахин уншиж судална. Нөгөө талаар үнэлгээний шалгуурын дээд түвшинд /IV түвшин/ хүрэхийн тулд бие даасан үйл ажиллагаа нь идэвхэжнэ, ач холбогдол өгнө. Багш өмнөх өгүүллэг, туужаас сонгон авч хэдэн үгэнд бичүүлэх, хугацааг тогтооно. Багш үнэлж, ангийн дунджийг тоон аргаар илэрхийлж гарааны түвшин тогтоож болно.

Тухайн анги 35 сурагчтай гэж үзвэл:

I түвшинд: Уншсан зохиолын талаар төрсөн сэтгэгдлээ бичиж байгаа-7

II түвшинд: Зохиолоос төрсөн сэтгэгдэл юунаас болж өөрт нь нөлөөлж байгааг тайлбарлаж бичиж байгаа-9

III түвшинд: Уншсан зохиолын талаар мэдрэмж сэтгэгдлээ бичихдээ уран дүрслэл ашиглаж бичиж байгаа-10

IV түвшинд: Уншсан зохиолын талаар мэдрэмж сэтгэгдлээ бичихдээ дүр, орчин, харилцан яриа оруулан уран дүрслэл ашиглан бичиж байгаа -9

Үүнийгээ дүгнэлт хийж баримт болгоод нэгэн улирлын дараа дахин түвшин тогтоогоод харьцуулалт хийж сурагчийн хөгжил, хичээлийнхээ үр дүнг тооцно. Энэ бол сурагчдаа оношилж байгаа хэрэг бөгөөд гарааны үнэлгээг хялбархан шийдэж буй арга болно.

Нөгөө талаар оношлох үнэлгээг сурах үйл ажиллагаанд гарч буй бэрхшээлийг олж илрүүлэхэд ашигладаг. Ангийн ихэнх сурагч гүйцэтгэж чадахгүй байгаа чадвар болон алдаатай хийж гүйцэтгэж буй агуулгыг мэдсэнээр багш тухайн агуулгыг эзэмшүүлэх арга барилаа өөрчилж болно. Юунаас шалтгаалаад амжилттай сурахгүй байгааг оношилсноор алдааг засах аргыг олдог. Үүнийг ихэвчлэн нэгж, бүлэг сэдвийн дараа /улирлын эцэс/ хийдэг. Үүний тулд бүлэг сэдвийн /нэгж/ дараа үнэлгээний шалгуур бүрээр оношилно. Жишээлбэл:

9 ангийн “Зохиолын орчин, нөхцөл байдал нь сэдэв утгыг тодруулахад нөлөөлж буйг шинжилдэг” гэсэн шалгуурын I түвшинд / Зохиолын орчин /орон, цаг/-ыг шинжилдэг/, II түвшинд /Зохиолын орчин, нөхцөл байдлыг шинжилдэг/ ангийн ихэнх хүүхдүүд хамрагдаж байгаа бол III, IV түвшинд яагаад хүрсэнгүй вэ? гэдэгт анхааран ажиллана. Зохиолын орчин, нөхцөл байдал нь сэдвийг хэрхэн тодруулж буйг дутуу ойлгосон эсвэл орчин, нөхцөл байдлыг утгатай холбож ойлгох нь дутмаг байгааг илрүүлнэ. Түүнийхээ дагуу дахин давтан судлах юм уу, эсвэл ухагдахууны тухай ойлголт өгч, жишээ баримтад тулгуурлан тайлбар бичүүлэх /яриулах/ замаар чадваржуулна.

**Орчин нөхцөл/ орон цаг:** Зохиолд хэзээ, хаана, ямар орчинд хэрэг явдал болж байгааг эрж хайж ямар үг, өгүүлбэрээр илэрч байгааг ялгуулна. Тэр нь сэдэв, утгыг бүрдүүлэхэд яаж нөлөөлөв гэдгийг л тодорхойлж холбож илэрхийлэхэд оршино.

**Утга/сэдэв:** Нэг зохиол хэд хэдэн утга санааг дэвшүүлж болно. Гол утга санаа гэдэг бол баригдашгүй зүйлийг эрж олох гээд учиргүй олон зүйл хийх хэрэггүй. Харин уншигч өөрийн үзэл бодлыг илэрхийлэх л чухал. Сэдэв гэдэг бол шууд ба шууд бусаар өгүүлж байгаа санаа юм. Зохиолыг унших үед танд төрсөн бодол буюу зохиолч танд юуг ойлгуулж, юуг сургахыг хүссэн байна, түүнийг сэдэв гэнэ. Уран зохиолын сэдэв нь ихэвчлэн амьдралыг таниулахад чиглэсэн байдаг. Зохиолч сэдвээр дамжуулан хүний мөн чанар, амьдралын утга учир болоод хорвоогийн жамыг уншигчдад таниулахыг зорьдог. Тэгвэл орчин, нөхцөл байдал нь сэдэв утгыг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг холбож тодорхойлуулна.

Үлгэрлэвэл: Ж. Лхагва “Эвэр” өгүүллэгийн үйл явдлын орчин нөхцөл, орон цагийг илэрхийлсэн үг хэллэгийг түүж бичих:

**Орчин нөхцөл нь:**

Янгирын сүрэг-

Хавцлын ирмэг нарийн жимээр бэдрэх-

**Орон цаг:** Алтайн хүрэн цохионы нөмөр-

Нэгэн хавсаргатай өдөр-  
Наран наашлах тутам-  
Энэ үеэс л ишиг тэх болох-  
Шүдлэн насанд эвэр нь хэвээ олж дугуйрах-  
Нэгэн өдөр янгирын сүрэг байрлалаа солих-  
Хожим нь-  
Хоёр жил өнгөрлөө-  
Эвэр хэдхэн сарын дотор...-  
Хайр найргүй довтолгох цаг хугацаа-

Үүрд замхарсан нь шувуу суунгуут үргэн нисэхийн адил- гэх мэт ялган бичээд /ухамсарлан бодоод/ ирэнгүүт сэтгэлд нэг зүйлийг бодогдуулах, орчин нөхцөл, орон цагийг илэрхийлсэн үгийн нэг нь нөгөөгүйгээр байж болохгүй юм байна гэдгийг ойлгож байгаа оюун тархины үйл ажиллагаа нь задлан шинжилж байгаа үйлдэл бөгөөд хариу үйлдэл нь тайлбараар илэрнэ.

Орчныг зохиолд оруулаагүй бол зохиолын утга санаанд өөрчлөлт орох уу?, эдгээр цагийн дарааллыг илэрхийлсэн үг хэллэгийг оруулаагүй бол зохиол бүтэх үү, ямар үүрэгтэй байна, утга санаанд яаж нөлөөв гэдгийг дүгнэлт хийлгэж тайлбарлуулснаар суралцахуйн үр дүнг хэрэгжүүлнэ.

Оношлох шалгалтын үр дүнгээс гарч буй алдаа, хоцрогдлыг энэ мэтээр тооцож, эргэж давтах эсвэл шинээр үзэх зохиолдоо түлхүү авч үзэх нь үр дүнтэй.

## Гурав. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар

### 3.1. Үнэлгээний даалгавар боловсруулах нь

VIII ангийн Уран зохиолын “Зохиолыг задлан шинжлэх” үнэлгээний нэгжид тулгуурлан бичгийн ажлын даалгавар боловсруулах аргачлал, үндэслэлийг тайлбарлая. (Ер нь нэг мэргэжлийн олон багш нартай) сургуулийн заах аргын нэгдэл хамтран ярилцаж боловсруулалт хийх нь хамгийн үр дүнтэй.

Суралцахуйн үр дүн нь:

- ✓ Зохиолын уран дүрслэл, утга санааг задлан шинжлэх
- ✓ Сурагч зохиолын бүтэц ба орчин нөхцөлийг дүрд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлаж чаддаг болсон байна.
- ✓ Сурагч зохиолын дүрийг тодорхойлж чаддаг болно.
- ✓ Шалгуур нь:
- ✓ Зохиолчийн үг сонголт, уран дүрслэлийг тайлан тайлбарлаж, утга санааг бүрдүүлэхийн тулд сэдвийг хэрхэн өргөжүүлснийг задлан шинжилдэг.
- ✓ Зохиолын эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайлал, төгсгөлийг ялган таньдаг.
- ✓ Зохиолын дүрийг тодруулж чаддаг.
- ✓ Сурагч зохиолын гол ба туслах, сөрөг дүрийг тодорхойлдог.

Тэгвэл гүйцэтгэлийн хүрэх түвшин нь өөрөө Булмын таксномийн танин мэдэхүйн түвшинд тулгуурласан учраас Блупринт зохиоход их дөхөм юм.

#### **Блупринт гэж юу вэ?**

Танин мэдэхүйн түвшнүүдээр даалгавруудынхаа тоог тогтооно. Өөрөөр хэлбэл үнэлэх төсөл зохионо. Ямар хичээлийн, хэддүгээр ангид, ямар төрлийн, юуны шалгалтыг, хэзээ, ямар хэлбэрээр, юунд тулгуурлан авсан нь тодорхой байдаг. /Хүснэгтээр үзүүлбэл/



Шалгалтын төрөл	Уран зохиолын “Өгүүлэг, тууж” нэгж хичээлийн шалгалт				
Анги	VIII				
Хугацаа	60 минут				
Шалгалтын хэлбэр	Бичгийн ажил				Огноо .....
Таксономи /Блум/	Сэргээн санах, ойлгох	Хэрэглэх / холбох/	Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх	Үнэлэх, бүтээх	Даалгаврын тоо
Даалгаврын тоо	1	4	3	2	10
Хэсэг I II	1	4	3	1	9
				1	1
Түвшний эзлэх хувь	10%	40%	30%	20%	100

Үнэлгээний хүрэх түвшин, хичээлийн агуулга, сурах бичгийн агуулга, хүүхдүүдийн бие даан уншсан чадвар, ойлголт мэдлэг, задлан шинжлэх чадвар зэргээс шалтгаалан асуулт даалгавраа хүнд хөнгөнийг тохируулна.

1. *Шалгуурын төгсгөлд байгаа үйл үгийг ашиглах* /таньдаг, тодорхойлдог, тодруулдаг, тайлбарладаг, үнэлгээ өгдөг гэх мэт/

Зохиолчийн үг сонголт, уран дүрслэлийг тайлан тайлбарлаж, утга санааг бүрдүүлэхийн тулд сэдвийг хэрхэн өргөжүүлснийг задлан шинжилдэг.

Зохиолын эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайлал, төгсгөлийг ялган таньдаг.

Зохиолын дүрийг тодруулж чаддаг.

Сурагч зохиолын гол ба туслах, сөрөг дүрийг тодорхойлдог.

Үүний учир нь 10 даалгаврыг танин мэдэхүйн түвшний алинд хамааруулж даалгавар боловсруулах вэ гэдэг л хамгийн чухал. Сэргээн санах түвшний даалгаварт - Зохиолын дүрийн зан төрхийн эерэг болохыг үгээр тоочиж эсвэл жишээ авч батлаарай гэх мэт.

Хэрэглэх түвшний дөрвөн даалгаварт II түвшний шалгуурыг харахаас гадна, танин мэдэхүйн түвшиндээ тохирч байгаа эсэхийг магадлаарай. Жишээ нь:

“Ёгтлолыг зохиолд хэрэглэсэн учрыг тайлбарлаарай” гэхээс илүүтэй ямар үүрэгтэй байгааг тайлбарлаарай, ёгтлолын аргыг зохиогч энэ хэсэгт хэрэглэснийг тайлбарлаарай гэх мэтээр хүүхдэд ойлгомжтой байдлаар асуулт даалгаврын найруулга, тавилд ач холбогдол өгөөрэй.

2. *Шалгуур бүрийн гүйцэтгэх чадвар, агуулгын гүнзгийрлийг харгалзан үзэх.*

Үнэлгээний шалгуурууд нь түвшин бүрээр өөр байгаа ч агуулгын гүнзгийрэл, гүйцэтгэлээс хамаарч задлан шинжлэх эсвэл үнэлэх бүтээх түвшний даалгавар болж болох талтай. “Уран дүрслэл /ёгтлол, егөөдөл/-ийг эхэд, зохиолд хэрэглэсэн учрыг тайлбарладаг” гэх II түвшний шалгуур юм. Гэвч зохиолоос авсан эшлэлд тулгуурлан тайлбарлуулбал сурагч хариулахдаа далд дүрслэлийг бүтээсэн талаас авч тодорхойлбол задлан шинжлэх чадварт хамааралтай болж байгаа юм. Тийм учраас үнэлэх гэдэг ганц хүний зүтгэлээр биш хамтын олны оролцоо, мэргэжил нэгтнүүдийн тус дэмд бий болох процесс юм. Нөгөөтээгүүр асуулт даалгавраа зохиох явцдаа хариултыг цуг хийх нь хамгийн чухал.

### Үнэлгээний марк схем гэж юу вэ?

Багш шалгалтын асуулт даалгавар зохиох явцдаа сурагчаас ирж болох хариултыг бичихийн зэрэгцээ, хэдэн оноог ямар хариултад өгөхөө тооцож гаргана. Учир нь сурагчаас ирэх хариултыг урьдчилан тооцоолсноороо бичгийн ажлыг засах оноожуулахад хялбар болдог. Асуулт зохиож эхлэхдээ л марк схемээ цуг хийвэл амар байдаг. Ингэхийн учир нь шалгалтын агуулга судалсан хичээлийн



/нэгж/ агуулгатай нийцэж байгаа эсэх, үнэлгээ бодитой, ойлгомжтой, алдаа мадаггүй, үнэн зөв байх зэрэг зарчмыг хангаж буй юм аа. Мөн хяналттай, нягт ажиллаж байгаа хэрэг. Даалгаврын тохирц ч сайн болдог. Хүснэгт ашиглаж хийвэл илүү гэдгийг загвараар үзүүллээ. Нэмэлт тайлбар хэсэгт өөр хувилбараар хариулж болох эсэх, оноожуулах, эс оноожуулахыг тайлбар бичнэ. Үүнийг марк схем гэнэ.

Асуултын дугаар	Оноо	Хариулт	Нэмэлт тайлбар
1	1	<input type="checkbox"/>	
2	2	<input type="checkbox"/>	
...		<input type="checkbox"/>	
8	2	<input type="checkbox"/>	

Бичгийн ажлын шалгалтын даалгавар боловсруулахдаа эхнээс нь цогц байдлаар /блупринт, марк схем, гүйцэтгэлийн үр дүнгийн шалгуур/ хандвал “Шалгалтын үнэлгээний сан” сайн бүрдэнэ. Шалгалт дууссаны дараа алдаа гарвал дахиж хянаж сайжруулах л үлдэнэ. Харин асуулт даалгавар нь оновчгүй, хэт ерөнхий, эсвэл бүтээлч биш хандвал олон дахин ажил болно.

#### Шалгалтын дараа яах вэ?

Нотолгоонд суурилсан шинжилгээ хийнэ. Сурагч нэг бүрийн гүйцэтгэлийн үр дүнг тооцон /хүснэгтэлж/ гаргаж боловсруулна. Мөн дүгнэлт бичнэ. Гүйцэтгэлийн үзүүлэлт нь “Тэд ямар байна”, “Тэд яаж хийх ёстой вэ?” гэх мэтэд хариулна. Багш ч “Би юу хийх ёстой вэ?” гэдгээ мэдэж авна.

## 3.2. НЭГЖ ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВРЫН ЖИШЭЭ:

### Рубрик ашиглан үнэлэх тухай

Рубрик (Rubric) гэдэг нь сурагчийг амаар, бичгээр, ажлын хуудсаар үнэлж болох үнэлгээний хэрэгсэл юм. Сурагчдыг оноожуулж үнэлгээ өгч байгаа багшийн үйл ажиллагаа нь бодит дүнд хүрэхэд түлхэц болохоос гадна, тэднийг илүү бүтээлч, бие даах чадвартай болоход сайнаар нөлөөлдөг. Рубрикийн гол зорилго нь гүйцэтгэлийг үнэлэхэд оршино. Хүссэн үр дүнд хүргэхийн тулд суралцагчийн эзэмших ёстой мэдлэг, чадвар, хандлагын жагсаалтыг гаргах.

Рубрик хийж, шүүн тунгааж, үнэлж дуусгасны дараа сургалтын үр дүн хэр байгааг дүгнэж /нэгж хичээлийн үр дүнг/ болдог. Өөрөөр хэлбэл багц шалгуур бүрд авсан оноогоор нь дүгнэж, ямар түвшинд байх ёстой вэ?, ямар агуулга, ухагдахуун, мэдлэг гэх мэт дутуу байв гэдгийг үзүүлэлтүүдээс шинжилж болдог.

Рубрик нь багшийн хувьд сурагчдын эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг төлөвлөх, түүний амжилтыг тогтмол хянахад туслах хүснэгт байдаг. Мөн ээлжит болон нэгж хичээлийн үр дүнг тодорхойлох, үр дүн тус бүрийн үнэ цэнийг тогтоох, хүрсэн амжилтыг бүртгэх, үйл ажиллагаа хэрэгжүүлэх, арга хэрэгсэл юм.

Рубрик нь багадаа гурван түвшнийг тодорхойлсон шалгууртай байх бөгөөд түвшин бүр нь өөрийн гэсэн багц шалгууртай байна.

Рубрикийн босоо шугам- Шалгуурууд, Хэвтээ шугам- Чанарын түвшнийг илэрхийлнэ. Рубрикийн төрлүүд:

1. Аналитик рубрик: Энэ рубрик нь гарах бүтээгдэхүүн болон үйл явцын хэсэг тус бүр эсвэл тодорхой зүйлийг олон баганаар дүрсэлдэг.
2. Дараалсан рубрик: Рубрикийг сургалтын нэг үр дүнгийн ахицыг тасралтгүй харахын тулд хэрэглэдэг. Жишээ нь: Тухайн сурагчийн долоо хоног бүрийн ахицыг тооцож тэмдэглэл хөтөлнө.
3. Үйл явцын рубрик: Сурагчдын гүйцэтгэсэн даалгаврын тайлбар, гүйцэтгэл, төлөвшил, хандлагыг оноожуулахад хэрэглэнэ. Жишээ нь: Манлайлал, багаар ажиллах чадвар гэх мэт.

**Рубрик ашиглан оноожуулах аргачлал.**

9-ангийн “Туурь өгүүллэг” нэгж хичээл. Үнэлгээний нэгж-2 Зохиолыг задлан шинжлэх. Зорилго: Зохиолыг задлан шинжилж буй чадварыг бичгийн ажлын гүйцэтгэлээр үнэлнэ. Багш үр дүнгийн үнэлгээний шалгуур буюу рубрикийг урьдчилан танилцуулж, хэрхэн яаж бэлдэх талаар зөвлөж танилцуулсны дараа асуулт боловсруулж бичгийн ажлын шалгалт авна.

Агуулга: Асуулт боловсруулна, сурагчдын ажлын гүйцэтгэлийг оноожуулна.

- Б. Ринчен “Нууцыг задруулсан захиа”, Ж. Лхагвын “Эвэр” зохиолоос үг сонголт, уран дүрслэл/бэлгэдэл/-ийг /2-5/ түүж, учир холбогдлоор далд утга /зохиолд гүн гүнзгий санаа байна уу, зохиолын төгсгөлд ямар гол санааг чухалчилсан гэх мэт/-ыг тайлан тайлбарлахуйц асуулт боловсруулна.
- Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, өнгөрснийг дурсах, ирээдүйг зөгнөх арга нь үйл явдлын цаг хугацааны дарааллыг өөрчлөхөд нөлөөлж байгааг тайлбарлахуйц асуулт боловсруулна.
- Зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдэв, хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг дүгнэхүйц асуулт боловсруулна.
- Зохиолын орчин, нөхцөл байдал нь сэдэв утга хоёрыг тодруулахад нөлөөлж буйг шинжлэхүйц асуулт боловсруулна.
- Зохиолын дүрийн зорилго, зан төрх, дүрүүдийн холбоо хамаарлаас дүрийн өсөлтийг дүгнэхүйц асуулт боловсруулна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн хүрэх түвшнийг рубрик болгон ашиглах боломжтой гэж үзэж байна. Шалгуур нь 1-4 оноотой ба энэ нэгжид 5 шалгуур байгаа учраас 1-20 оноо болно.

Гүйцэтгэл	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮРЭХ ТҮВШИННИЙ ШАЛГУУР			
	I	II	III	IV
Зохиолын далд утгыг тайлан тайлбарлах	Зохиолоос уран дүрслэл, бэлгэдлийг ялган таньдаг.	Зохиолчийн сонгосон өвөрмөц үг, уран дүрслэл /бэлгэдэл/-ийг ялган таньж, утгыг тайлбарладаг.	Зохиолын үг сонголт, уран дүрслэл /бэлгэдэл/-ээр далд утгыг тайлан тайлбарладаг.	Зохиолын үг сонголт, уран дүрслэл /бэлгэдэл/-ийн учир холбогдлоор далд утга /зохиолд гүн гүнзгий санаа байна уу, эсвэл өвөрмөц содон санаа байна уу, зохиолын төгсгөлд ямар гол санааг чухалчилсан гэх мэт/-ыг тайлан тайлбарладаг.
Оноожуулалт	0-1 оноо	2 оноо	3 оноо	4 оноо
Зохиолын өгүүлэгдэхүүн бүтцийн нөлөөг тайлбарлах	Зохиолын өгүүлэгдэхүүний бүтцийг тайлбарладаг.	Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, өнгөрснийг дурсаж, ирээдүйг зөгнөж өгүүлсэн ямар хэрэг явдал гарч байгааг тайлбарладаг.	Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, өнгөрснийг дурсаж, ирээдүйг зөгнөж өгүүлсэн ямар хэрэг явдал үйл явдлын өрнөлд нөлөөлж байгааг тайлбарладаг.	Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, өнгөрснийг дурсаж, ирээдүйг зөгнөх арга нь үйл явдлын цаг хугацааны дарааллыг өөрчлөхөд нөлөөлж байгааг тайлбарладаг.
Оноожуулалт	0-1 оноо	2 оноо	3 оноо	4 оноо

Зохиолын хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг дүгнэх	Зохиолын сэдвийг дүгнэдэг.	Зохиолын сэдэв, хам сэдвийг дүгнэдэг.	Зохиолын сэдэв, хам сэдвийг хөгжүүлснийг дүгнэдэг.	Зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдэв, хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг дүгнэдэг.
Оноожуулалт	0-1оноо	2 оноо	3 оноо	4 оноо
Зохиолын нөлөөг шинжлэх	Зохиолын орчин /орон, цаг/ -ыг шинжилдэг.	Зохиолын орчин, нөхцөл байдлыг шинжилдэг.	Зохиолын орчин, нөхцөл байдал нь сэдэв, утгын аль нэгийг тодруулахад нөлөөлж буйг шинжилдэг.	Зохиолын орчин, нөхцөл байдал нь сэдэв утга хоёрыг тодруулахад нөлөөлж буйг шинжилдэг.
Оноожуулалт	0-1оноо	2 оноо	3 оноо	4 оноо
Зохиолын дүрийг дүгнэх	Дүрийн зорилгыг дүгнэдэг.	Дүрийн зорилго, зан төрхийг дүгнэдэг.	Зохиолын дүрийн зорилго, зан төрх, дүрүүдийн холбоо хамаарлыг дүгнэдэг.	Зохиолын дүрийн зорилго, зан төрх, дүрүүдийн холбоо хамаарлаас дүрийн өсөлтийг дүгнэдэг.
Оноожуулалт	0-1оноо	2 оноо	3 оноо	4 оноо

## Дөрөв. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал

Шалгагдсан сурагчдын бичгийн ажлын гүйцэтгэлд тулгуурлан дүн шинжилгээ хийнэ. Сурагчдын авсан онооны нэгтгэлээр сурагч бүрийн зохиолыг задлан шинжлэх чадвар ямар байгаа болон сургалтын үр дүнг шинжилнэ. Тухайн ангийг 30 сурагчтай гэж үзье:

Гүйцэтгэл	Зохиолын далд утгыг тайлан тайлбарлах				Зохиолын өгүүлэгдэхүүн бүтцийн нөлөөг тайлбарлах				Зохиолын хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг дүгнэх				Зохиолын нөлөөг шинжлэх				Зохиолын дүрийг дүгнэх			
	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV
Онооны нэгтгэл	2	8	12	8	4	5	14	7	5	18	5	2	1	14	8	4	1	5	16	8
Хувь	6,67	26,7	40,0	26,7	13,3	16,7	46,7	23,3	16,7	60,0	16,7	6,7	3,33	46,7	26,7	13,3	3,3	17	53	27

Хэвтээ шугамын үзүүлэлтээс дүгнэлт хийж, юуг анхааран ажиллах вэ? гэдгээ баримтад тулгуурлан гаргана. “Зохиолын хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг дүгнэх” буюу зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдэв, хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг дүгнэх чадварын - I, II түвшний эзлэх хувь 76,7 % байгаа нь асуултын нөхцөл буруу болсон аль эсвэл энэ түвшний чадварыг ахиулахад анхаарна гэсэн үг. Өөрөөр хэлбэл зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдэв, хам сэдвийг хэрхэн хөгжүүлдгийг бататган үзнэ, судална. Мөн тодорхой ойлголт ухагдахууныг зөв авч үзнэ.

**Сэдэв:** Бичвэрийн үндсэн санааг авч үзнэ. Эхэд дэвшүүлсэн асуудал буюу юуны тухай бичсэн үндсэн суурь мэдээлэл.

**Хам сэдэв/ Хам бичвэр:** Бичвэрийн дотор үзүүлсэн орон, цаг болоод нөхцөл байдлыг хам сэдэв гэнэ. Хам сэдэв ерөнхийдөө нийгэм, түүх, соёлын нөхцөлүүд юм уу, нөхцөл байдлын онцлогийг харуулна. Хам сэдэв нь санааг ойлгох явцад уншигч сонсогчдын дурдсан танил бус үгийн хэрэглээгээр илэрнэ.

Гүйцэтгэл	Зохиолын далд утгыг тайлан тайлбарлах				Зохиолын өгүүлэгдэхүүн бүтцийн нөлөөг тайлбарлах				Зохиолын хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг дүгнэх				Зохиолын нөлөөг шинжлэх				Зохиолын дүрийг дүгнэх				Бүгд оноо
	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	
Анун			3			2				2					3				3		<b>13</b>
Бадрах		2					3				3				3					4	<b>15</b>

Сэдвийг хөгжүүлэхэд зохиогчоос яаж хандаж ямар асуудлыг авч ил ба далд утгаар илэрхийлэв гэдгийг зохиолын жишээ баримтад тулгуурлан тайлбарлуулах, тайлбарлах. Харин хам сэдвийн хөгжүүлснийг нийгэм, түүх, соёлын онцлогийг хэрхэн бий болгов гэдгээс үндэслэнэ. Энэ үзүүлэлт нь багшийг ур чадварын хувьд өөрийгөө хөгжүүлэх, шинэ аргад суралцах, өөр арга хэлбэрийг эрэлхийлэхэд тустай. Энэ мэтчилэн шалгалтын үр дүн бүрээр /баримт нотолгоонд суурилсан/ дүгнэлт хийнэ.

Харин Босоо шугамын үзүүлэлтээс ангийн сурагчдын задлан шинжилж буй чадварыг харах /дүгнэх/ бөгөөд хувь сурагч юуг анхаарах, цаашид хэрхэн хандах, яаж өөрчлөгдөхийг зөвлөнө.

Үлгэрлэвэл: Анун, Бадрал нарын хувьд нийт 20 оноо авах бөгөөд хувилан үзвэл 65, 75 хувьтай л байна. Үүний тулд хувь сурагчид эргэж унших, жишээгээ буруу сонгож байна, хэт ерөнхий байна, ингэж хандана гэх мэт зөвлөмж, тусламж, дэмжлэг хүргэхээс өгсүүлээд олон арга зам бий. Сурагчид хэдийгээр зохиолыг ойлгосон ч дутуу хандах, тайлбарлах чадвар дутмаг байгаад дүгнэлт хийж гүйцээн ойлгох, аливаад өнгөц биш гүн хандах, арга барилтай болох талаар зөвлөнө.

Түүнчлэн хэвтээ болон босоо шугамын нотолгоонд суурилсан шинжилгээ хийж аль аль талаас авч үзэх нь бидний ажлын үр дүнг улам ахиулах юм. Өөрөөр хэлбэл нэг талаас багш заах ур чадвар, агуулгыг бүхлээр буюу хэсэгчлэн авч үзэх гэх мэт ач холбогдолтой. Нөгөө талаас хувь сурагч багшийн зөвлөгөөнд /feedback/ тулгуурлан хөгжих боломж дүүрэн байна.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ:

- Уран зохиолын хичээлийн сургалтын үр дүнг үнэлэх шалгуур /Бүрэн дунд боловсролын түвшин/-2021
- “Уран зохиол” сурах бичиг 6,7,8,9
- “Суурь боловсролын хөтөлбөр” /сайжруулсан/ 2019
- “Ерөнхий боловсролын сургуулийн уран зохиолын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамж”- суурь боловсрол 6, 7, 8, 9 анги
- “Сургалтын хөтөлбөрийг дэмжих арга зүйн зөвлөмж”-Монгол хэл, Үндэсний бичиг, Уран зохиол VI-IX УБ 2020
- “Блумын таксономийн танин мэдэхүйн түвшин, мэдлэгийн төрлүүд”
- “Сонгох-хариултат даалгаврыг шинжлэх арга зүйн нэгэн хувилбар” лекц
- “Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал” РР
- “Үнэлгээний шалгуур боловсруулах нь” РР
- Г. Нандинбилиг “Эх зохиолыг задлан шинжилж үнэлэх арга зүй” УБ 2018
- Н. Батбаяр “Үнэлгээний онол арга зүй- эх хэл” УБ 2017

**ЕБС-ийн Уран зохиол хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж боловсруулсан ажлын хэсэг:**

Н.Батбаяр 33-р сургуулийн багш, тэргүүлэх, магистр

**Хөндлөнгийн шинжээч:**

Ө.Цэндсүрэн Монгол улсын гавьяат багш

**Техникийн редактор:**

Т.Отгон-Эрдэнэ Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, тэргүүлэх зэрэгтэй  
Ш.Сувдмаа Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр

**Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:**

С.Мөнхмаа Интерпресс ХХК-ийн дизайнер, магистр

**Цаасны хэмжээ:** А4

**Хэвлэлийн хуудас:** 3.5 х.х



*Дэлгэрэнгүй мэдээллийг:*

[www.eec.mn](http://www.eec.mn)



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо,  
Энхтайваны өргөн чөлөө, Оюуны ундраа группын байр,  
Утас/Факс: 976-11 7011- 8486  
И-мэйл: [info@eec.mn](mailto:info@eec.mn) Вэб: [www.eec.mn](http://www.eec.mn)